



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

756.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 125	3006
757.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 126	3006
758.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 127	3007
759.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 128	3007

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

760.	Журам батлах тухай	Дугаар 200	3008
761.	Журам батлах тухай	Дугаар 201	3016

	. 09᠗	. 0᠑᠗	. 0᠑᠗	. 0᠑᠗	. 0᠑᠗	. 0᠑᠗
<b>ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ</b>	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ	ᠨᠠᠭᠠᠰᠢᠰᠢᠷ
᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗	᠑᠐᠐᠓᠗



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 125

Улаанбаатар  
хот

### Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дашдэлэгийн Ганзоригийг Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2. Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дашдэлэгийн Ганзоригийг Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар  
хот

### Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 191 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Цэвээндоржийн Алтанцэцэгийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.



2.Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Цэвээндоржийн Алтанцэцэгийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2022 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар  
хот

### **Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Мянгаагийн Баясгаланг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Мянгаагийн Баясгаланг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2022 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 128

Улаанбаатар  
хот

### **Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн



тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 189 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Оюунбатын Оюунгэрэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Оюунбатын Оюунгэрэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2022 оны 5 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар  
хот

### **Журам батлах тухай**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ  
ХАРИУЦАГЧ**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

Засгийн газрын 2022 оны 200 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧААС НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ  
БИЙ БОЛГОХ, НИЙТЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
АШИГЛАХ НӨХЦӨЛ, ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь мэдээлэл хариуцагч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.1-д заасны дагуу нээлттэй, хаалттай болон хязгаарлалттай мэдээллээс нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

**Хоёр.Нээлттэй өгөгдөл бий болгох**

2.1.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.1-д заасан нээлттэй өгөгдлийг бий болгоход дараах шаардлага тавигдана:

- 2.1.1.хууль ёсны эх сурвалжаас цуглуулсан байх;
- 2.1.2.магадлахад үнэн зөв, бодитой байх;
- 2.1.3.агуулгын хувьд хэсэгчлээгүй, бүрэн гүйцэд байх;
- 2.1.4.хувийн ашиг сонирхол, итгэл үнэмшлийн нөлөөлөл ороогүй байх;
- 2.1.5.мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код ашигласан байх;
- 2.1.6.нээлттэй өгөгдлийг бусад нээлттэй өгөгдөлтэй холбож ашиглах боломжтой байх;
- 2.1.7.нээлттэй өгөгдлийн мөр бүрийг ялган таних, бусад нээлттэй өгөгдөлтэй холбох түлхүүр талбартай байх;
- 2.1.8.түлхүүр талбарыг аль болох өөрчлөхгүй, урт хугацаанд тогтвортой хэрэглэдэг байх;



2.1.9.хууль тогтоомжоор зөвшөөрсөн, шинжлэх ухааны үндэслэл бүхий, энгийн, ойлгомжтой, нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо, агуулга, тоо, үсэг, тусгай тэмдэглэгээ ашигласан байх;

2.1.10.мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээнээс хэтрэхгүй байх;

2.1.11.бусад нээлттэй өгөгдөлтэй шууд харилцан хамааралтай, эсхүл түүний агуулгаас хамаарах бол эшлэл, тайлбарыг тусгах.

2.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох зорилгоор энэ журамд нийцүүлэн дотоод заавар баталж, мөрдүүлж болно.

2.3.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийг өөрийн санаачилгаар, эсхүл хүн, хуулийн этгээдийн хүсэлтэд үндэслэн бий болгож болно.

2.4.Хүн, хуулийн этгээд нээлттэй өгөгдөл бий болгох талаар хүсэлт гаргасан тохиолдолд мэдээлэл хариуцагч хүсэлтийг хүлээн авах эсэхийг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэх бөгөөд хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд нээлттэй өгөгдлийг 30 хоногийн дотор бий болгож, хүн, хуулийн этгээдэд хүргүүлнэ.

2.5.Мэдээлэл хариуцагч нь өмнөх бүтэц, агуулга, бэлтгэсэн арга зүй, эх үүсвэр, ашиглах нөхцөлөө алдаж, хурдан өөрчлөгдөх шинж чанартай нээлттэй өгөгдөл болон нэмэлт өртөг шингэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээг бий болгоход тохиромжтой нээлттэй өгөгдлийг машин унших форматаар, онлайн (API) хэлбэрээр, эсхүл бүхэлд нь татаж авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тайлбар: “машин унших формат” гэж нээлттэй өгөгдлийг компьютерын программаар ялгах, таних, хэсэгчилж авах боломжтой бүтэцлэгдсэн форматыг ойлгоно.

2.6.Мэдээлэл хариуцагч шинээр нээлттэй өгөгдөл бий болгох зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6-д заасан жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.7.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинээр нээлттэй өгөгдөл бий болгох талаар мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн саналыг нэгтгэн Засгийн газарт хүргүүлнэ.



### **Гурав.Нээлттэй өгөгдлийг нийтлэх**

3.1.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.

3.2.Нээлттэй өгөгдлийг нийтлэхэд дараах шаардлага тавигдана:

3.2.1.2-оос доошгүй тооны машин унших формат (XML, CSV, JSON, RDF, GeoJSON гэх мэт нийтлэг ашиглагддаг)-тай байх;

3.2.2.төлбөргүй татаж авах боломжтой байх;

3.2.3.нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөлийг заах;

3.2.4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6-д заасны дагуу Засгийн газраас баталсан жагсаалтад заасан хугацаанд шинэчлэгддэг байх;

3.2.5.нийтэлсэн нээлттэй өгөгдөлд өөрчлөлт орсон тохиолдолд өмнөх болон шинэчилсэн хувилбарыг хамт нийтлэх;

3.2.6.өөрийн цахим хуудсанд нээлттэй өгөгдлийн цэс үүсгэх.

### **Дөрөв.Нээлттэй өгөгдлийг ашиглах**

4.1.Хүн, хуулийн этгээд нь нээлттэй өгөгдлийг дараах нөхцөлийн дагуу ашиглана:

4.1.1.нээлттэй өгөгдлийг чөлөөтэй ашиглах;

4.1.2.арилжааны бус нөхцөлөөр ашиглах;

4.1.3.нээлттэй өгөгдлийг боловсруулсан этгээдийн нэрийг дурдаж ашиглах;

4.1.4.бусад.

4.2.Хүн, хуулийн этгээд нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхтэй холбоотой энэ журмын 2.1, 3.2-т заасан шаардлагыг хангуулах талаар өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

### **Тав.Нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх удирдлага, зохион байгуулалт**

5.1.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, шинэчлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хариуцсан албан хаагчийг томилж, ажиллуулна.





5.2.Нээлттэй өгөгдөл хариуцах үүргийг хавсран гүйцэтгэхээр бол томилогдсон албан хаагчид хуульд заасны дагуу нэмэгдэл олгож болно.

5.3.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана.

5.4.Энэ журмын 5.3-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Тайланд дараах мэдээллийг тусгана:

5.4.1.нийтэлсэн нээлттэй өгөгдлийн тодорхойлолт, хэмжээ;

5.4.2.нээлттэй өгөгдлийг нийтэлсэн давтамж, татаж авсан тоон үзүүлэлт;

5.4.3.шинээр бий болгох нээлттэй өгөгдөл, түүний тодорхойлолт;

5.4.4.нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглахтай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал.

5.5.Нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагч нь дараах ажлыг хариуцан гүйцэтгэнэ:

5.5.1.нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

5.5.2.нээлттэй өгөгдлийг Засгийн газраас тогтоосон хугацаанд нийтлэх;

5.5.3.нээлттэй өгөгдөл шинээр бий болгох талаар санал гаргах;

5.5.4.нээлттэй өгөгдөлтэй холбоотой хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, хариу өгөх.

5.6.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, шинэчлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.6.1.хүн, хуулийн этгээдийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

5.6.2.нээлттэй өгөгдлийг хүн, хуулийн этгээдэд сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах;

5.6.3.нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх техник болон программ хангамжийг шинэчлэн сайжруулах.



Засгийн газрын 2022 оны 200 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## **ТӨРИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (цаашид “систем” гэх)-ийг хөгжүүлэх, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах, нээлттэй өгөгдөл нийтлэх, удирдах, ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг хэрэгжүүлэхэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн гаргасан бусад актыг дагаж мөрдөнө.

### **Хоёр.Системийн шаардлага, үйл ажиллагаа**

2.1.Систем нь Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу нээлттэй өгөгдлийг нийтлэх, олон нийтэд түгээх, нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөлийн дагуу өгөгдлийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах хэрэгсэл бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.систем нь дурын веб хөтөч дээр ажиллах боломжтой байх;

2.1.2.системд нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөлийг ойлгомжтой тайлбарласан байх;

2.1.3.нээлттэй өгөгдөлд хандахад хялбар, хуулах, татаж авах боломжтой байх;

2.1.4.бүртгэгдсэн бүх утгаар хайлт хийх, бүлэглэх, ангилах, эрэмбэлэх боломжтой байх;

2.1.5.нээлттэй өгөгдөлд хандсан тоон мэдээлэл, лог бүртгэлтэй байх;

2.1.6.нээлттэй өгөгдлийн статистик үзүүлэлтээр тайлан, мэдээ гаргадаг байх;

2.1.7.бусад системүүдтэй холбогдож (API) харилцан мэдээлэл солилцох боломжтой байх;

2.1.8.өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрийг эргэн мэдээлэх боломжтой байх;

2.1.9.мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээллийг тодорхой харуулдаг байх;

2.1.10.нээлттэй өгөгдөл нийтлэхэд шаардлагатай мета-өгөгдлийг авах боломжтой байх;

2.1.11.нийтэлсэн нээлттэй өгөгдлийн мета-өгөгдөл болон формат, хэмжээ, нийтэлсэн болон өөрчлөлт хийсэн огноог харуулдаг байх;

2.1.12.нийтэлсэн нээлттэй өгөгдлийг архивлах, архивын өгөгдлийг харах, татан авах боломжтой байх.

Тайлбар: “мета-өгөгдөл” гэж өгөгдлийн бүтэц, формат, чанар, агуулга, мэдээлэл хариуцагч, эх сурвалж, боловсруулсан арга зүйг тайлбарласан өгөгдлийг ойлгоно.

### **Гурав.Систем хариуцагч, мэдээлэл хариуцагчийн эрх, үүрэг**

3.1.Систем хариуцагч нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.системийг тогтмол хөгжүүлж, байнгын, хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах;

3.1.2.системийн хэвийн үйл ажиллагааг хангах зохицуулагчийг томилох;

3.1.3.мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан системд мэдээлэл хариуцагчийн эрхийг үүсгэж, тохиргоо хийх;

3.1.4.системийн мэдээллийн санг зохион байгуулах, нээлттэй өгөгдлийн бүлэг, ангилал үүсгэх;

3.1.5.системд хандсан хандалт, лог бүртгэлийг хөтлөх, хянах;

3.1.6.системийн мэдээллийн сангийн нөөц хувилбарыг долоо хоног бүр хийх, системийн архив үүсгэх;

3.1.7.системтэй холбоотой асуудлаар мэдээлэл хариуцагч, хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол хүлээж авах нөхцөлийг бүрдүүлэх, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу мэдэгдэх;



3.1.8.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.11-д заасны дагуу нийтэлсэн нээлттэй өгөгдөлтэй холбоотой гомдол ирсэн тохиолдолд нээлттэй өгөгдөлд хандах хандалтыг түр зогсоох;

3.1.9.мэдээлэл хариуцагчид систем ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж өгөх, гарын авлагаар хангах, сургалт зохион байгуулах.

3.2.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан этгээд байх бөгөөд дараах эрх, үүрэгтэй:

3.2.1.өөрийн цахим хуудсанд нийтэлсэн нээлттэй өгөгдлийг системд байршуулах;

3.2.2.систем ашиглахтай холбоотой систем хариуцагчаас өгсөн заавар, зөвлөмжийг мөрдөх;

3.2.3.нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагчийн мэдээллийг систем хариуцагчид хүргүүлэх, өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх;

3.2.4.системд нэвтрэхдээ систем хариуцагчаас олгосон эрхийг ашиглах;

3.2.5.хуульд заасан бусад.

### **Дөрөв.Системийн нууцлал, аюулгүй ажиллагаа**

4.1.Систем хариуцагч нь системийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.2.Мэдээлэл хариуцагч нь хандах эрхийн нууцлалыг хангаж, нэвтрэх нэр, нууц үгээ алдсан тохиолдолд систем хариуцагчид мэдэгдэж, даруй солино.

4.3.Системийг “Үндэсний дата төв” УТҮГ дээр байршуулна.

### **Тав.Бусад**

5.1.Систем хариуцагч нь системийн ашиглалтын тайланг гаргаж нийтэд мэдээлнэ.

-оОо-



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.16-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.

3.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 411 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ  
ХАРИУЦАГЧ**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

Засгийн газрын 2022 оны 201 дүгээр  
тогтоолын хавсралт

## **НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР БАЙРШУУЛЖ НИЙТЛЭХ, ШИНЭЧЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч мөн хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид “мэдээлэл хариуцагч” гэх) нь хууль болон энэ журамд нийцүүлэн нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих талаар дотоод журам батлан мөрдүүлж болно.

### **Хоёр.Нээлттэй мэдээллийн сан үүсгэх, цахим хуудсанд байршуулж нийтлэх**

2.1.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан өөрт хамаарах нээлттэй мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж, “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага” Монгол Улсын MNS 6285:2017” стандартыг хангасан, Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)-д нийцсэн өөрийн цахим хуудас (цаашид “цахим хуудас” гэх)-д байршуулж нийтэлнэ.

2.2.Мэдээлэл хариуцагч нь энэ журмын 2.1-д заасан цахим хуудсанд мэдээллийн агуулгыг бүлэглэх, цэс үүсгэх, хайлтын системд хайлт хийх, цахим хуудасны бусад мэдээлэлтэй холбоосоор харилцан холбогдох боломжтой байдлаар байршуулж нийтэлнэ.

2.3.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцах ажилтныг (цаашид “эрх бүхий ажилтан” гэх) томилон ажиллуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

2.4.Эрх бүхий ажилтан нь цахим хуудсанд байршуулж нийтлэх нээлттэй мэдээллийн үнэн зөв байдлыг хангана.

2.5.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудсанд эрх бүхий ажилтны нэр, албан тушаал, холбоо барих мэдээллийг нийтэлнэ.

2.6.Нээлттэй мэдээллийг дүрс, видео, аудио хэлбэрээр цахим хуудсанд байршуулсан тохиолдолд түүний тайлбарыг оруулна.

2.7.Нээлттэй мэдээлэл нь их хэмжээтэй тохиолдолд цахим хуудсанд ачаалал үүсгэхгүй байдлаар байршуулна.

2.8.Нээлттэй мэдээлэл агуулсан мэдээллийн сан үүсгэхдээ “Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Кирилл болон монгол үсгийн нэгдсэн код” MNS 5552:2005” стандартыг дагаж мөрдөнө.

### **Гурав.Нээлттэй мэдээлэл, цахим хуудсыг шинэчлэх**

3.1.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудсанд байршуулж нийтэлсэн нээлттэй мэдээллийг шинэчлэх тохиолдолд шинээр веб холбоос оноож, өмнөх хувилбарыг архивлаж, хандах боломжийг бүрдүүлнэ.

3.2.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудсыг шинэчлэх, эсхүл шинээр үүсгэх тохиолдолд архивласан болон байршуулж нийтэлсэн нээлттэй мэдээллийг тухайн байршуулж нийтэлсэн огноогоор шинэ цахим хуудсанд хуулах, эсхүл устахгүй байхаар шинэчлэлийг хийнэ.

3.3.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд, бусад мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол хяналт тавина.

### **Дөрөв.Цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих**

4.1.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудасны мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах бөгөөд холбогдох стандартыг дагаж мөрдөнө.

4.2.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, саатал гарсан тохиолдолд шалтгааныг даруй тодруулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.



4.3.Мэдээлэл хариуцагч нь албан ёсны эх сурвалжийг үндэслэн нээлттэй мэдээлэл байршуулж нийтлэх, шинэчлэхдээ цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

### **Тав.Бусад зүйл**

5.1.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэхэд шаардагдах программ хангамж, техник хэрэгсэл, хөрөнгө, хүний нөөц, ажлын байрны нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэхтэй холбогдох үүргийг эрх бүхий ажилтны албан тушаалын, эсхүл ажлын байрны тодорхойлолтод тусгана.

-ооо-

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1

**Индекс: 200003**



